



## “НЭГ ДЭЛХИЙ НЭГ СУРГУУЛЬ” БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР



**Нэг Дэлхий Нэг Сургууль** боловсролын хөтөлбөр нь Бүгд Найрамдах Чех улсын П.И.Н ОУТББ хэрэгжүүлдэг боловсролын хөтөлбөр юм. Энэхүү боловсролын хөтөлбөр нь баримтат киног аудиовидео хичээлээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хүний эрх, ардчиллын үнэт зүйлс, хүн чанар болон ардчиллын үнэт зүйлс зэрэг сэдвийн хүрээнд нийгмийн боловсрол олгох, багш нарт аудиовидео хичээлийг хэрхэн сургалтанд ашиглах талаарх шинэлэг заах арга зүйн мэдлэг, чадвар олгоход гол анхаарлаа хандуулан ажиллах юм. Хөтөлбөрийн хүрээнд баримтат кино, түүн дээр тулгуурлан бэлтгэгдсэн заах аргазүйн багц материалыг багш нарт санал болгоно.



Уг хөтөлбөр нь Монгол Улсын нийт 20 ерөнхий боловсролын сургуульд хэрэгжих ба сонгогдсон сургуулиудад төслийг удирдан хэрэгжүүлэх 50 багшийг дадлагажуулан сургах юм.



This project is funded by  
The European Union



Mongolian Education Alliance  
Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

## Төслийг санхүүжүүлэгч:

Европын Холбоо

## Төсөл хэрэгжих бүс нутаг:

Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймаг

## Төсөл хэрэгжих хугацаа:

2012-2014 он



Хөтөлбөрийн хүрээнд 10 сурагчдын кино клуб бий болгож тус клубд хичээлийн бус цагаар сурагчдын дунд Хүний эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хүний наймаа, яс үндэс, арьс өнгө, шашин шүтлэг, хүйсээр ялгаварлан гадуурхах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг, тэмцээн, уралдаан, мэтгэлцээн зохион байгуулж сурагчдын нийгмийн идэвхи санаачлагыг нэмэгдүүлэн есрийн үзэл бодолтой болон төлөвшихөд хувь нэмрээ оруулах юм.

Сүүлийн жилүүдэд Нэг Дэлхий Нэг Сургууль боловсролын хөтөлбөр нь зөвхөн Чех улсаар хязгаарлагдалгүй бусад улс орнуудад хэрэгжиж 2008 оноос эхлэн олон улсын Watch and Change хөтөлбөрийн тэргүүлэгч хөтөлбөр болоод байгаа билээ. Одоогын байдлаар Чех, Лебан, Румин, Гүрж, Косово, Босни Герцеговна, Польш, Эстони зэрэг улс орнуудад амжилттай хэрэгжиж байна.

